



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/1/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас:323266 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Ш.Наран Утас:323266 Цахим хаяг: naransh@audit.gov.mn Аудитор: Э.Цэлмэгбаяр Утас:323266 Цахим хаяг: tselmegbayare@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	5
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	7
2.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3. Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1. Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний үйл ажиллагаа	12
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
1. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1. Ерөнхий зүйл	21
4.2. Материаллаг байдал.....	21
4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.1. Төлбөрийн акт	26
5.2. Албан шаардлага	28
5.3. Зөвлөмж.....	32
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	34

Хүснэгт 1.	Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт
Хүснэгт 2.	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт 3.	Авлагын үлдэгдэл
Хүснэгт 4.	Урьдчилгааны үлдэгдэл
Хүснэгт 5.	Бараа материалын үлдэгдэл
Хүснэгт 6.	Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт 7.	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл
Хүснэгт 8.	Өр төлбөрийн үлдэгдэл
Хүснэгт 9.	Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл
Хүснэгт 10.	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЗД	Баянзүрх дүүрэг
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
БТСХ	Биеийн тамир, спортын хороо
ДАШТ	Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОУТ	Олон улсын тэмцээн
ОХУ	Оросын холбооны улс
САГ	Санхүүгийн аудитын газар
САУЭШТ	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СУГ	Соёл урлагийн газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УБЗБ	Улаанбаатар зочид буудал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮШБ	Үндэсний шигшээ баг
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХУД	Хан-Уул дүүрэг



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН
ХОРООНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БИЛЭГТ ТАНАА

2026.03.25 № 807

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгдсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар *Хязгаарлалттай Санал Дүгнэлтийн Үндэслэл* хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалтай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 8,396.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,396.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн;
- Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,958.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй, хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй;
- Худалдан авах ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулан нийт 1,192.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн;

- Төрийн өмч хөрөнгийг иргэн хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, сонгон шалгаруулалтгүй, үнэ төлбөргүй ашиглуулсан, ашиглалтын зардал нийт 410.8 сая төгрөгийг төсвөөс төлсөн, төрийн өмчийг түрээслэх, түрээсийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэхтэй холбоотой хууль, журмын заалтуудыг зөрчсөн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3-15.1.8, 15.2.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, УСНББОУС-1,2,17 дахь заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн ба зохистой байх” баталж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Харьяа 33 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 12 байгууллага “Өөрчлөлтгүй”, 3 байгууллага “Хязгаарлалттай”, 1 байгууллага “сөрөг” дүгнэлт авч, 17 байгууллага түүвэрт хамрагдан Спортыг дэмжих сан төсөв батлагдаагүй тул аудитад хамрагдаагүй.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэн авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Биеийн тамир, спортын улсын хороо нь олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдын урамшуулалд 1,945.2 сая төгрөг, Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжихэд 590.0 сая төгрөг, Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжихэд 11,619.4 сая төгрөг, Олимп, паралимпийг дэмжих үйл ажиллагаанд 578.4 сая төгрөг, бусад спортыг дэмжихэд 797.9 сая төгрөг, үндэсний тэмцээнд наадамд 915.2 сая төгрөг, Иргэдийн идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжихэд 145.5 сая төгрөг, Спортын өндөр амжилт гаргасан тамирчдын шагнал урамшуулалд 1,340.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

1.1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		15,295,607.8	14,392,305.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	23,144.7	-
33	АВЛАГА	5а, 5б, 6а,	657,359.1	784,818.4
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	3,776,338.7	2,989,997.1
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	4,491,657.0	4,270,381.3
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		6,347,108.4	6,347,108.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		162,595,368.2	194,623,845.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б,	162,595,368.2	194,623,845.1
39300	Биет хөрөнгө		148,889,035.6	175,163,472.8
39303	Биет бус хөрөнгө	13	13,706,332.6	19,460,372.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		177,890,976.0	209,016,150.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		270,743.4	503,583.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		270,743.4	503,583.5
41300	Өглөг		270,743.4	503,583.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		177,620,232.6	208,512,566.8
51	Засгийн газрын хувь оролцоо		177,620,232.6	208,512,566.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		55,031,145.7	51,361,195.2
51200	Хуримтлагдсан үр дүн		102,445,466.7	134,313,594.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		20,143,620.1	19,953,439.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		177,890,976.0	209,016,150.3

1.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		105,742,372.0	113,590,151.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	23,689,417.9	113,590,151.2
120	Нийтлэг татварын бус орлого		23,689,417.9	43,607,561.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		82,052,954.2	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	87,686,764.1	79,548,449.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		87,686,764.1	79,548,449.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		80,075,879.1	72,639,956.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		21,956,197.9	29,499,009.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,686,233.5	3,566,767.0
2103	Байр ашиглалттай холбоотой зардал		243,694.9	253,583.2
2104	Хангамж, бараа материалын зардал		1,045,526.8	879,035.9
2105	Норматив зардал		482,568.7	344,687.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		832,263.9	207,765.5
2107	Томилолт, зочны зардал		75,785.8	62,267.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,591,591.4	14,540,374.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		21,162,016.3	23,286,466.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		7,610,885.0	6,908,492.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		18,055,608.0	34,041,701.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		23,325.0	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		594,752.1	2,626,041.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		17,484,180.9	31,415,659.7

1.3. Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023.12.31-нээрх үлдэгдэл	326,512,984.0		326,512,984.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(166,376,932.3)		(166,376,932.3)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,136,051.7		160,136,051.7
9	Тайлант үеийн үр дүн	17,484,180.8		17,484,180.8
10	2024.12.31-нээрх үлдэгдэл	177,620,232.5		177,620,232.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(587,045.0)		(587,045.0)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	177,033,187.5		177,033,187.5
19	Тайлант үеийн үр дүн	31,415,659.7		31,415,659.7
20	2025.12.31 үлдэгдэл	208,512,566.8		208,512,566.8

1.4. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	87,732,829.2	70,584,879.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,261,212.4	70,584,879.8
120	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	82,471,616.8	-
1311	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,187,623.6	70,447,590.1
II	УРСГАЛ ЗАРДАЛ	86,187,623.6	70,447,590.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,616,273.5	63,396,403.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,076,879.1	29,506,657.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,686,142.2	3,569,302.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,406.8	253,583.2
2104	Хангамж, бараа материалын зардал	470,737.7	478,789.7
2105	Нормативд зардал	1,512,401.7	437,883.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,638,705.4	268,274.3
2107	Томилолт, зочны зардал	75,278.3	62,267.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,515,401.5	14,004,507.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,398,320.8	14,815,137.8
III	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,571,350.1	7,051,186.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,545,205.6	137,289.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,522,060.9	160,434.4
VI	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,522,060.9	160,434.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,522,060.9)	(160,434.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	23,144.7	(23,144.7)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	23,144.7
102	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,144.7	-

1.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	59,493,501,600.00	52,574,167,873.60	6,919,333,726.40	88.37
12	Татварын бус орлого	59,493,501,600.00	52,574,167,873.60	6,919,333,726.40	88.37
122	Тусламжийн орлого	59,189,501,600.00	52,257,309,275.60	6,932,192,324.40	88.29
122005	Төсвөөс санхүүжих	59,189,501,600.00	52,257,309,275.60	6,932,192,324.40	88.29
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,493,501,600.00	52,523,393,313.60	6,970,108,286.40	88.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,493,501,600.00	52,523,393,313.60	6,970,108,286.40	88.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,798,815,900.00	48,194,286,725.06	3,604,529,174.94	93.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,916,770,900.00	27,271,596,261.78	1,645,174,638.22	94.31
210101	Үндсэн цалин	13,956,070,500.00	16,410,507,427.52	(2,454,436,927.52)	117.59
210102	Нэмэгдэл	10,295,768,500.00	6,095,144,568.90	4,200,623,931.10	59.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,827,227,400.00	3,151,170,949.37	(323,943,549.37)	111.46
210104	Урамшуулал	1,837,704,500.00	1,604,356,648.89	233,347,851.11	87.30
210105	Гэрээт ажлын хөлс		10,416,667.10	(10,416,667.10)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,603,356,800.00	3,306,897,550.34	296,459,249.66	91.77
210201	Тэтгэврийн даатгал	2,468,650,800.00	2,282,033,056.35	186,617,743.65	92.44
210202	Тэтгэмжийн даатгал	283,987,800.00	262,796,431.53	21,191,368.47	92.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	142,196,200.00	135,040,667.18	7,155,532.82	94.97
210204	Ажилгүйдлийн даатгал	141,650,900.00	122,662,919.05	18,987,980.95	86.60
210205	Эрүүл мэндийн даатгал	566,871,100.00	504,364,476.23	62,506,623.77	88.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,052,400.00	225,052,400.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	121,653,400.00	92,706,284.00	28,947,116.00	76.21
210302	Түлш, халаалт	63,441,900.00	84,051,930.17	(20,610,030.17)	132.49
210303	Цэвэр, бохир ус	39,957,100.00	48,294,185.83	(8,337,085.83)	120.87
2104	Хангамж, бараа материалын зардал	382,220,600.00	260,905,295.66	121,315,304.34	68.26
210401	Бичиг хэрэг	55,321,400.00	44,199,185.00	11,122,215.00	79.90
210402	Тээвэр, шатахуун	30,090,600.00	31,588,477.00	(1,497,877.00)	104.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	103,170,900.00	64,005,479.66	39,165,420.34	62.04
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	51,691,400.00	25,413,460.00	26,277,940.00	49.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	141,946,300.00	95,698,694.00	46,247,606.00	67.42
2105	нормативд зардал	586,763,400.00	406,812,650.00	179,950,750.00	69.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	404,605,100.00	403,812,650.00	792,450.00	99.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	182,158,300.00	3,000,000.00	179,158,300.00	1.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,972,200.00	45,128,320.00	37,843,880.00	54.39
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,972,200.00	15,128,320.00	7,843,880.00	65.85
210604	Урсгал засвар	60,000,000.00	30,000,000.00	30,000,000.00	50.00
2107	Томилолт, зочны зардал	28,908,900.00	28,908,850.00	50.0	100.0
210702	Дотоод албан томилолт	28,908,900.00	28,908,850.00	50.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,016,730,000.00	12,088,246,022.67	928,483,977.33	92.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,796,341,100.00	11,977,850,358.04	818,490,741.96	93.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,565,600.00	11,794,500.00	4,771,100.00	71.20
210803	Даатгалын үйлчилгээ	14,997,500.00	2,375,130.00	12,622,370.00	15.84
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,649,200.00	2,088,551.00	4,560,649.00	31.41

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,989,000.00	464,200.00	3,433,800.00	11.91
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	62,739,900.00	37,462,633.63	25,277,266.37	59.71
210807	Газрын төлбөр	115,538,700.00	56,210,650.00	59,328,050.00	48.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,956,040,700.00	4,560,739,374.61	395,301,325.39	92.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,952,588,200.00	4,557,286,874.61	395,301,325.39	92.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,452,500.00	3,452,500.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,694,685,700.00	4,329,106,588.54	3,365,579,111.46	56.26
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	140,091,800.00	130,693,450.00	9,398,350.00	93.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,554,593,900.00	4,198,413,138.54	3,356,180,761.46	55.57
610001	БАЙГУУЛЛАГЫН ТОО	33.00	33.00	-	100.0
62	Төсвийн байгууллага	33.00	33.00	-	100.0
620001	АЖИЛТНЫ ТОО	856.00	846.00	-	98.83
620002	Удирдах ажилтан	75.00	75.00	-	100.00
620003	Гүйцэтгэх ажилтан	781.00	771.00	-	98.83

1.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	16,073,162,772.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,073,162,772.75
122	Тусламжийн орлого	16,073,162,772.75
1221	Хандив тусламж /дотоод/	16,073,162,772.75
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,073,162,772.75
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,000,000.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,090,589,056.03
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,637,411,847.22
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,295,161,872.50
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,410,015,104.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,410,015,104.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,305,563,154.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,236,325,012.89
210101	Үндсэн цалин	929,441,383.96
210102	Нэмэгдэл	1,148,932,945.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,728,457.72
210104	Урамшуулал	110,760,225.87
210105	Гэрээт ажлын хөлс	1,462,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,056,930.03
210201	Тэтгэврийн даатгал	198,246,467.59
210202	Тэтгэмжийн даатгал	16,913,948.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,475,623.93
210204	Ажилгүйдлийн даатгал	7,291,477.19
210205	Эрүүл мэндийн даатгал	29,129,413.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,530,791.09
210301	Гэрэл, цахилгаан	26,990,790.09
210303	Цэвэр, бохир ус	1,540,001.00
2104	Хангамж, бараа материалын зардал	218,883,430.97
210401	Бичиг хэрэг	9,582,710.00
210402	Тээвэр, шатахуун	57,579,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,652,338.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,313,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,756,101.98
2105	нормативд зардал	31,071,000.00
210502	Хоол, хүнс	1,890,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,181,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	336,391,635.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	169,376,688.00
210602	Тавилга	640,000.00
210604	Урсгал засвар	166,374,947.90
2107	Томилолт, зочны зардал	33,358,820.00
210702	Дотоод албан томилолт	33,358,820.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,935,761,509.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,917,361,229.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,411,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,387,636.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	455,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,023,500.00
210807	Газрын төлбөр	8,089,444.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,224,184,024.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,886,974,486.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	337,209,538.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,451,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,451,950.00

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний үйл ажиллагаа

Биеийн тамир, спортын улсын хороо нь хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Биеийн тамир, спортын улсын хороо нь үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх;
- Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барих;
- Спортын сургалт - дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах;
- Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;
- Биеийн тамир, спортын салбарын болон хорооны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Биеийн тамир, спортын улсын хороо нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүргэлд мөрддөг хууль тогтоомж, бодлогын чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Биеийн тамир, спортын тухай хуулийн 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн шинэчилсэн найруулга;
- Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар “Засгийн газрын агентлагийн бүтэц орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”

Биеийн тамир, спортын улсын хорооны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсэн дүн шинжилгээний үр дүнд дотоод хяналтын тогтолцооны зохион байгуулалт, хэрэгжилт нь үр нөлөөгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг, хэрэгжүүлсэн ажлын талаар хангалттай ойлголт олж авсны үндсэн дээр дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	23,144.7	-	(23,144.7)
Авллага	657,359.1	784,818.4	127,459.3
Урьдчилгаа	3,776,338.7	2,989,997.1	(786,341.6)
Бараа материал	4,491,657.0	4,270,381.3	(221,275.7)
Бусад эргэлтийн хөрөнгө	6,347,108.4	6,347,108.4	-
Үндсэн хөрөнгө	162,595,368.2	194,623,845.1	32,028,476.9
Нийт хөрөнгө	177,890,976.0	209,016,150.3	31,125,174.30
Өр төлбөр	270,743.4	503,583.5	232,840.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	177,620,232.6	208,512,566.8	30,892,334.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	177,890,976.0	209,016,150.3	31,125,174.3

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өмнөх оноос 31,125.1 сая төгрөгөөр буюу 17.5 хувиар өссөн. Энэ нь Баянхонгор, Дорнод аймгуудад шинээр ашиглалтад орсон усан бассейн, спорт цогцолборын барилга нийт 30,356.0 сая төгрөг, БТСУХ-ны Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хамаарах "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор"-ын барилга барих зориулалттай 99,920 м.кв, 5,454.9 сая төгрөгийн үнэлгээтэй газрыг үндсэн хөрөнгөд бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитад хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.4.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн данс тайлант хугацаанд 23.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Кассад байгаа бэлэн мөнгө	1,877.0	-	(1,877.0)
Төрийн сангийн харилцах	21,267.7	-	(21,267.7)
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Дүн	23,144.7	-	(23,144.7)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

БТСУХ харьяа байгууллагууд нь тайлант хугацаанд хууль тогтоомж зөрчиж, 2,504.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал:

- Өвөрхангай аймгийн БТСГ нь үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, 28.9 сая төгрөгийн зарцуулалт гаргасан.
- Орхон аймгийн БТСГ нь түрээсийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, авлага барагдуулж орлого бүрдүүлэх талаар анхаарч ажилладаггүй.
- Хөвсгөл аймгийн БТСГ нь спорт заалны түрээсийн орлогыг 2.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Мөн байгууллагын үйл ажиллагааны орлогыг бэлэн мөнгөөр авч зарцуулдаг, холбогдох баримтын бүрдэл хангалтгүй, хяналт сул.
- Өмнөговь аймаг 49.9 сая төгрөгийн орлогын тооцоог нийлж, баталгаажуулаагүй.
- Архангай аймгийн БТСГ "Бүсчилсэн хөгжлийн иргэдийн спортын их наадам" -ын төсөвт тусгагдаагүй шууд дамжуулал болон зар контентод 10.5 сая төгрөг,
- БТСУХ -оос тусгай олимпын Дэлхийн өвлийн наадамд оролцох тамирчдад 1.2 сая төгрөгийн тушаал шийдвэрээс илүү хувцас авсан байхад тооцоо нийлж, авлагаар тусгаагүй.
- БТСУХ нь үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд байдаггүй 16 хүнд 65.6 сая төгрөгийг үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардлаас олгосон.
- БТСУХ-ны даргын "Биатлоны Үндэсний шигшээ багт тэмцээнд оролцох, бэлтгэлд хамрагдах зардал гаргах тухай" А/66 дугаар тушаалаар Дэлхийн цомын аварга шалгаруулах олимпын эрхийн оноо олгох Европын цуврал тэмцээн, бэлтгэлд 1 тамирчин яваагүй, төсөв тусгагдсан улсын тэмцээнд оролцоогүйгээс нийт 28.3 сая төгрөгийн төсөв хэмнэгдсэн байхад Биатлоны холбоо нь буцаан тушаагаагүй.
- БТСУХ олон жилийн хугацаанд өөрийн эзэмшлийн байрны 71.7 хувийг буюу 6238.3 м2 талбайг үнэ төлбөргүй хувь хүн, хуулийн этгээдэд ашиглуулж төсөвт орлого төвлөрүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй мөн байр ашиглалт, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний зардалд нь 423.5 сая төгрөгийг төлсөн.
- БТСУХ нь өмнөх онуудад нас барсан 8 ахмадад 16.1 сая төгрөгийг олгосон.
- Говьсүмбэр аймгийн БТСГ үндэсний тэмцээн, наадмын үйл ажиллагааны зардлаас 1.5 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн.
- Багануур дүүргийн БТСГ байгууллагын үйл ажиллагаа зохион байгуулахдаа шүүгчдийн болон шагналт байрны шагнал 23.5 сая төгрөгийг албан хаагчийн хувийн дансаар дамжуулан олгосон.
- Архангай аймгийн БТСГ нь албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо зөрүүтэй тооцоноос 0.15 сая төгрөг, илүү цагийн нэмэгдлийг зөрүүтэй тооцоноос 0.05 сая төгрөг, нийт 0.2 сая төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон.
- Хэнтий аймгийн БТСГ нь үр дүнгийн урамшуулал 2.9 сая төгрөгийг он дамнуулан, олговол зохих хувь хэмжээнээс 7.9 сая төгрөг илүү, ёс зүйн дэд хорооны урамшуулал 3.0 сая төгрөгийг цалин сангаас, нийт 13.8 сая төгрөг олгосон.
- Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 2.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. /Дархан-Уул аймгийн БТСГ 0.5 сая төгрөг, Хөвсгөл аймаг 1.9 сая төгрөг/
- Төв аймгийн БТСГ 1.6 сая төгрөгийн цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд дутуу, Хөвсгөл аймгийн БТСГ 4.9 сая төгрөгийг илүү тайлагнасан.
- Албан томилоттой давхардуулан 1.5 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон. /Төв аймгийн БТСГ 0.2 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ 1.3 сая төгрөг/
- Төв аймгийн БТСГ нь ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчтай ээлжийн амралт 0.6 сая төгрөгийг олгоогүй, мөн албан хаагчид үр дүнгийн урамшуулал 0.2 сая төгрөг илүү олгосон.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- БТСУХ-ны даргын "Иргэдийн спортын наадам зохион байгуулах тухай" А/177 дугаар тушаалаар 4 хүнд нийт 2.0 сая төгрөг, "Дархан хотод хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил хийх" А/185 дугаар тушаалаар 2 хүнд 0.4 сая төгрөг, нийт 2.4 сая төгрөгийн томилолт илүү олгосон. /БТСУХ 2.4 сая төгрөг/
- БТСУХ нь "Биеийн тамир спортын статистикийн эмхэтгэл 2024"-ийг хэвлэх байгууллагыг сонгохдоо 3 газраас үнийн санал авч 72 нүүр номыг хэвлэх хамгийн бага үнийн саналаар Сод пресс ХХК-г сонгосон боловч уг эмхэтгэлийг 66 нүүртэй хэвлүүлэх гэрээ 14.1 сая төгрөгөөр байгуулж хийлгүүлсэн нь ТБОНӨХБАУХАТ хуульд заасан оролцогчийг тэгш боломжоор хангаагүй.
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүй 192.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. /Багахангай БТСГ 29.3 сая төгрөг, Нийслэлийн БТСГ 96.3 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн БТСГ 66.6 сая төгрөг/
- БТСУХ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан 986.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.
- Баянхонгор аймгийн БТСГ нь тэмцээн уралдааны дэмжлэгт 19.8 сая төгрөгийн бэлэн мөнгө олгосон ч бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй байна.
- БТСУХ-оос санхүүжилт авсан холбоод нь гүйцэтгэлийн баримтаа бүрэн гүйцэд өгдөггүй, тооцоо нийлж авлага, өглөг баталгаажуулдаггүйгээс 517.7 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг тооцоо нийлэлгүй зардлаар бүртгэсэн.
- БТСУХ нь тушаал шийдвэр, анхан шатны баримтын бүрдэлгүй 1.4 сая төгрөгийг УБЗБ ХХК-д рестораны төлбөр төлсөн.
- БТСУХ-оос өмнөх онд хууль бусаар ажлаасаа халагдсан 2 албан хаагчийн шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 32.1 сая төгрөгийг цалингийн зардлаас, 0.1 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас олгосон ч буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаас төрд учруулсан хохирлыг төлүүлээгүй.
- БТСУХ нь Албан хаагчдын албан тушаалын чиг үүрэгтэй давхардуулан нийт 40.9 сая төгрөгийн зардал гаргасан.

3.4.2. Авлага

Авлага данс 784.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу өмнөх оноос 127.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Б			
Ажиллагчидтай холбогдсон авлага	4,647.6	2,499.1	(2,148.5)
Төлбөртэй үйлчилгээний авлага	152,866.8	62,259.7	(90,607.1)
Татаас, санхүүжилтийн авлага	400.0	316,576.4	316,176.4
Байгууллагаас авах авлага	492,995.0	399,033.6	(93,961.4)
Хувь хүмүүсээс авах авлага	6,449.7	4,449.7	(2,000.0)
Дүн	657,359.1	784,818.4	127,459.3

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын данс өмнөх оноос 127.5 сая төгрөгөөр өссөн нь 15 байгууллагад 316.6 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага нэмэгдсэнтэй холбоотой. Авлага дансны үлдэгдэл 784.8 сая төгрөг байна. /Архангай аймгийн БТСГ 15.4 сая төгрөг, Баянхонгор аймгийн БТСГ 13.7 сая төгрөг, Булган аймгийн БТСГ 1.2 сая төгрөг, Говь-Алтай аймгийн БТСГ 39.2 сая төгрөг, Дорноговь аймгийн БТСГ 62.2 сая төгрөг, Дорнод аймгийн БТСГ 4.2 сая төгрөг, Дундговь аймгийн БТСГ 2.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн БТСГ 20.5 сая төгрөг, Өмнөговь аймгийн БТСГ 9.9 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн БТСГ 9.6 сая төгрөг, Төв аймгийн БТСГ 2.2 сая төгрөг, Увс аймгийн БТСГ 0.6 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ 1.5 сая төгрөг, Нийслэлийн БТСГ 65.7 сая төгрөг, СХД БТСХ 9.2 сая төгрөг, ЧД БТСХ 3.5 сая төгрөг, Налайх дүүргийн БТСХ 0.2 сая төгрөг, Орхон аймгийн БТСГ 9.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн БТСГ 3.6 сая төгрөг, БТСУХ 483.9 сая төгрөг, САУЭШТ 25.9 сая төгрөг/

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн БТСГ халаалтын төсвийг төсөвлөснөөс 12.2 сая төгрөг илүү тооцон шилжүүлсэн;
- Орхон аймгийн БТСГ иргэн, аж ахуй нэгжээс авах 9.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- БТСУХ-ны авлага дансанд 2 буюу түүнээс дээш жилийн насжилттай 33.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- БТСУХ нь Пара Жүдо бөхийн Үндэсний шигшээ багийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох багийн эмчийн зардал 8.2 сая төгрөгийг эмчийн дансанд шилжүүлсэн боловч тус эмч нь яваагүй улмаас 5.5 сая төгрөгийг БТСУХ-ны дансанд буцаан төлсөн, зөрүү 3.2 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан;
- Өмнөговь БТСГ нь он дамнасан 0.6 сая төгрөгийн авлага барагдуулаагүй.

3.4.3. Урьдчилгаа

Урьдчилгаа данс 2,989,997.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу өмнөх оноос 786.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгааны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	3,776,338.7	2,989,997.1	(786,341.6)
Дүн	3,776,338.7	2,989,997.1	(786,341.6)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд БТСУХ-ны Улаанбаатар спорт менежмент ХК-д олгосон “Олон улсын залуучуудын наадам”-ын зориулалттай спортын ордны барилгын тоног төхөөрөмжийн санхүүжилт 2,620.8 сая төгрөг, үндэсний шигшээ баг, холбоодод олгосон тэмцээн уралдааны санхүүжилт 367.8 сая төгрөг, САУЭШТ-ын эм боох материал худалдан авахтай холбоотой 1.4 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар тайлагнасан байна.

3.4.4. Бараа материал

Бараа материал данс 4,270.3 сая төгрөг буюу 221.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Түүхий эд материал	2,156,079.4	1,990,033.7	(166,045.7)
Дуусаагүй үйлдвэрлэл	98,849.7	-	(98,849.7)
Бэлэн бүтээгдэхүүн	7,375.0	7,769.0	394.0
Хангамжийн материал	1,261,706.4	1,288,259.7	26,553.3
Бусад хангамжийн материал	967,646.6	984,318.8	16,672.2
Дүн	4,491,657.0	4,270,381.3	(221,275.7)

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансанд үлдэгдэлтэй 221.3 сая төгрөгөөр буурахад Дорнод аймгийн БТСГ-ын дуусаагүй үйлдвэр дансны үлдэгдэл 98.8 сая төгрөгөөр буурсан, харьяа байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 166.0 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант хугацаанд бараа материалын зарцуулалттай холбоотой 376.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

- Говьсүмбэр аймгийн БТСГ нь аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 2.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн;
- Тээвэр шатахууны зардлыг жолоочийн тооцооны хуудас, анхан шатны баримтгүй, эм боох материалыг эмчилгээний хуудасгүй зарцуулсан нийт 9.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн./ БТСУХ 7.5 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ 0.5 сая төгрөг, САУЭШТ 0.6 сая төгрөг, САУЭШТ 1.1 сая төгрөг/;
- БТСУХ нь бараа материалыг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, нэр төрлийг тусгаагүй, бөөн дүнгээр орлого авч зардалд бүртгэдэг, тараалтын хуудасгүй, зарцуулалтыг нотлох баримтгүй, тооцооны дансаар дамжуулдаггүй нийт 316.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн;

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Хөвсгөл аймгийн БТСГ-ын бараа материалын дансанд биетээр байхгүй, тухайн цаг хугацаандаа зарлагадаагүй үлдэгдэлд бүртгэлтэй эд зүйлсийг 42.2 сая төгрөгийн эд зүйлсийг өмч хамгаалах комисс, удирдлагын тушаал шийдвэргүй зардалд тайлагнасан.

3.4.5. Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө данс 6,347.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бусад үндсэн хөрөнгө	6,347,108.4	6,347,108.4	-
Дүн	6,347,108.4	6,347,108.4	-

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.6. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн данс 194,623.8 сая төгрөг буюу өмнөх оноос 32,028.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Биет хөрөнгө	148,889,035.4	175,163,472.8	26,274,437.3
Барилга, байгууламж, орон сууц	126,565,674.7	149,148,550.7	22,582,876.1
Авто-тээврийн хэрэгсэл	767,479.7	899,687.2	132,207.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,823,488.6	6,452,716.0	(1,370,772.6)
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,441,755.9	2,680,875.3	(760,880.6)
Зам, гүүрний байгууламж	214,234.6	188,439.0	(25,795.8)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	514,200.0	514,200.0	-
Бусад үндсэн хөрөнгө	6,752,943.0	13,279,715.7	6,526,772.7
Дуусаагүй барилга, байгууламж	2,807,470.0	1,997,500.0	(809,970.0)
Ном	1,788.9	1,788.9	-
Биет бус хөрөнгө	13,706,332.5	19,460,372.3	5,754,039.7
Программ хангамж	335,181.7	291,312.5	(43,869.3)
Бусад биет бус хөрөнгө	13,371,150.8	19,169,059.8	5,797,909.0
Дүн	162,595,368.2	194,623,845.1	32,028,476.9

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 32,028.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Усан бассейн, спорт цогцолборын барилга 13,046.5 сая төгрөг, Дорнод аймгийн усан бассейн бүхий спорт цогцолборын барилга 17,309.5 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ИТХ-ын даргын 2025 оны 44 дүгээр захирамжаар 308.8 сая төгрөгийн автобус, суурин компьютер шинээр авч, бүртгэлд тусгасан.

Мөн БТСУХ нь бусад үндсэн хөрөнгө дансанд Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хамаарах "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолбор"-ын барилга барих зориулалттай 99,920 м.кв, 5,454.9 сая төгрөгийн үнэлгээтэй газрыг бүртгэсэн нь үндсэн хөрөнгийн дансны өсөлтөд гол нөлөө үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт алдагдсан, бүртгэл тайлагнал хангалтгүй байгаатай холбоотой 5,278.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй 2,958.2 сая төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүргэх арга хэмжээг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлж, бүртгээгүй. /СХД БТСХ-д 4 төрлийн 138.6 сая төгрөг, ХУД БТСХ-д 4 төрлийн 94.5 сая төгрөг, Багахангай дүүргийн БТСХ-д 3 төрлийн 28.8 сая төгрөг, БЗД БТСХ-д 52 нэр төрлийн 52.4 сая төгрөг, Баянхонгор аймгийн БТСГ-т 72 нэр төрлийн 203 ширхэг 85.2 сая төгрөг, БТСУХ-д 3,156 ширхэг 2,504.8 сая төгрөг, Өмнөговь аймгийн БТСГ-т 44 ширхэг үлдэх өртөггүй машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Хөвсгөл аймгийн БТСГ-т 65 нэр төрлийн 80 ширхэг 53.9 сая төгрөг./
- Дундговь, Архангай аймгийн БТСГ-ууд нь жилийн эцсийн тооллого хийгээгүй;

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- БТСУХ нь спортын холбоодод 872.9 сая төгрөгийн 958 ширхэг бараа материал, 1,672.3 сая төгрөгийн 698 ширхэг үндсэн хөрөнгийг өгч ашиглуулдаг боловч эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байхгүй, коджуулалт хийгээгүй, Биеийн тамир, спортын цахим мэдээллийн сангийн 236.7 сая төгрөгийн программ хангамжийг 2020 онд тендер шалгаруулалтаар хийлгэсэн боловч биет бус хөрөнгөд бүртгээгүй;

3.4.7. Өр төлбөр

Өглөгийн данс үлдэгдэл 503.6 сая төгрөг буюу 232.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Ажилчидтай холбогдсон өглөг	519.8	25,157.8	24,638.0
Байгууллагад төлөх өглөг	269,430.4	270,273.3	6.5
Хувь хүмүүст төлөх өглөг	793.2	208,152.3	207,359.1
Дүн	270,743.4	503,583.5	232,840.1

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд өглөгийн данс 232.8 сая төгрөгөөр нэмэгдэж 503.6 сая төгрөг болсон нь Сангийн яамнаас 2025 оны 4 дүгээр улиралд санхүүжилт татсантай холбоотой ихэнх өр төлбөр үүссэн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлтэй 20 байгууллага байна. /Баян-Өлгий аймгийн БТСГ 104.8 сая төгрөг, Баянхонгор аймгийн БТСГ 5.9 сая төгрөг, Дорноговь аймгийн БТСГ 0.7 сая төгрөг, Дорнод аймгийн БТСГ 5.0 сая төгрөг, Дундговь аймгийн БТСГ 0.9 сая төгрөг, Завхан аймгийн БТСГ 0.2 сая төгрөг, Өвөрхангай аймгийн БТСГ 0.8 сая төгрөг, Өмнөговь аймгийн БТСГ 6.8 сая төгрөг, Төв аймгийн БТСГ 17.6 сая төгрөг, Увс аймгийн БТСГ 4.8 сая төгрөг, Ховд аймгийн БТСГ 0.1 сая төгрөг, Хөвсгөл аймгийн БТСГ 101.6 сая төгрөг, Хэнтий аймгийн БТСГ 4.0 сая төгрөг, Нийслэлийн БТСГ 7.6 сая төгрөг, СХД БТСГ 9.6 сая төгрөг, Багахангай дүүргийн БТСХ 0.2 сая төгрөг, Налайх дүүргийн БТСХ 0.1 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн БТСГ 1.4 сая төгрөг, БТСУХ 189.0 сая төгрөг, САУЭШТ 42.4 сая төгрөг/.

Аудитын илрүүлэлт:

Төв аймгийн БТСГ нь бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой 3.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

3.4.8. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо данс үлдэгдэл 208,512.5 сая төгрөг буюу 30,892.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Засгийн газрын оруулсан капитал	55,031,145.7	51,361,195.2	(3,669,950.5)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	2,706,893.6	6.5
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	177,444.0	207,359.1
Хуримтлагдсан үр дүн	102,445,466.7	134,313,594.8	31,868,128.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,143,620.1	19,953,439.2	(190,181.0)
Дүн	177,620,232.6	208,512,566.8	30,892,334.2

Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 208,512.5 сая төгрөг болж, 31,125.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Биеийн тамир, спортын улсын хорооны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд 155,990.5 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын засгийн газрын бүтцийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд шилжсэнээр биеийн тамир спортын салбарын урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсвийн төсөлд хүргүүлсэн саналаас 87,730.4 сая төгрөгөөр бууруулж, Биеийн тамир, спортын улсын хороонд 32,411.6 сая төгрөг, аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газарт 33,672.9 сая төгрөг, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвд 1,439.9 сая төгрөг, Спортыг дэмжих санд 735.5 сая төгрөг нийт 68,260.1 сая төгрөг баталсан байна.

Төсвийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 15,566.0 сая төгрөгөөр, үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардлыг 11,677.7 сая төгрөгөөр, дотоодод зохиогдох олон улсын тэмцээний зардлыг 9,667.9 сая төгрөгөөр, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих зардлыг 19,535.2 сая төгрөг тус тус бууруулан баталсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар БТСУХ ТТЗ-ийн төсвийг 7 дугаар сард тодотгон 9,070.6 сая төгрөгөөр бууруулж 59,189.5 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс БТСУХ-д 27,076.7 сая төгрөг, САУЭШТ-д 1,297.8 сая төгрөг, аймаг, нийслэлийн БТСГ-т 30,815.0 сая төгрөг, спортыг дэмжих санд төсөв батлаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 59,189.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 52,257.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 52,257.3 сая төгрөг буюу 88.29 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,645.1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 296.4 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 121.3 сая төгрөг, нормативд зардал 179.9 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 37.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 928.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 395.3 сая төгрөг, урсгал шилжүүлэг 3,365.6 сая төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5 харуулав.

3.5.3. Нэмэлт төсөв

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 50.0 сая төгрөг, улс орон нутгийн нөөц хөрөнгөөс 6,090.6 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8,637.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,295.2 сая төгрөг, нийт 16,073.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 2,236.3 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 261.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 28.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 218.9 сая төгрөг, норматив зардалд 31.1 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 336.4 сая төгрөг, томиллолт, зочны зардалд 33.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,935.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10,224.2 сая төгрөг нийт 15,305.6 сая төгрөгийг зарцуулж, 104.4 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлснээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын засгийн газрын бүтцийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Биеийн тамир, спортын улсын хорооны хөрөнгө оруулалтын данс, барьцаа баталгаа, техник хяналтын дансыг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд 2024 оны 9 дүгээр сард шилжүүлсэн байна.

1. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Биеийн тамир спортын улсын хороо, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг хангах, төсөвт зохицуулалт хийхдээ журам зааврыг баримтлах, үйл ажиллагааны орлогыг төлөвлөх, холбогдох журам зааврыг сайжруулах, мөрдөж ажиллах, батлагдсан бүтэц орон тоог бүрдүүлэх, биет бус хөрөнгийн бүртгэл, хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитор Э.Цэлмэгбаяр нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 487 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 85,705.4 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 433.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг 2025 оны төсвийн төсөлд төлөвлөөгүй бөгөөд батлагдсан төсвийг хэтрүүлээгүй, сул орон тоог хадгалах, дотоод цахим сүлжээ ашиглах зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант хугацаанд хэмнэлтийн тухай хуулийг баримтлаагүй 136.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

- Газрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалаар албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор " албан хаагчдын нэгдсэн сургалт, спортын арга хэмжээ"-г зохион байгуулж 1.2 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. /Дорноговь аймгийн БТСГ 1.2 сая төгрөг/
- Бараа материалын дансанд 17.1 сая төгрөгийн медаль их хэмжээгээр нөөцөлсөн байна. /СХД БТСГ 17.1 сая төгрөг/
- Хөвсгөл аймгийн БТСГ нь 1.2 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин БТСУХ нь Биеийн тамир, спортын улсын зөвлөгөөн зохион байгуулж 117.1 сая төгрөг зарцуулсан. /БТСУХ-ны албан хаагчдын спорт өмсгөлийн зардалд 1.2 сая төгрөг, автобус түрээсэнд 3.0 сая төгрөг, албан хаагчдын томилолтын зардалд 13.6 сая төгрөг, 700 ширхэг дэвтэр, балны зардалд 12.9 сая төгрөг, спортын тэмцээн уралдааны зардалд 33.7 сая төгрөг, урлагийн тоглолтод 12.0 сая төгрөг, өдөр, оройн хоолонд 24.4 сая төгрөг, хулдаасан хэвлэл, стэнд 15.9 сая төгрөг/

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

БТСУХ-ны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой 4,184.8 сая төгрөгийн 26 зөрчил илэрсэн. Үүнээс харьяа 9 байгууллагад 1,271.9 сая төгрөгийн 21 зөрчил илэрсэн бол түүврийн 2 байгууллагад 2,912.9 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэн байна.

4.4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 4,029.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3,943.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 86.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Түүврийн байгууллага

Түүврийн байгууллагуудын аудитаар Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс нийт 2,912.9 сая төгрөгийн 43 мэдээллийг байршуулаагүй, 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан зөрчилд 1 албан шаардлага 1 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 625.4 сая төгрөгийн 22 гүйлгээ байршуулаагүй. /БТСУХ 600.5 сая төгрөгийн 20 гүйлгээ, САУЭШТ 24.9 сая төгрөгийн 2 гүйлгээ/;
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 2,287.5 сая төгрөгийн 21 мэдээлэл байршуулаагүй байна. /БТСУХ нь 2,253.1 сая төгрөгийн 13 мэдээлэл, САУЭШТ нь 34.3 сая төгрөгийн 8 мэдээлэл/
- БТСУХ нь аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 1 мэдээлэл, САУЭШТ нь Санхүүгийн тайлан, аудитын тайлан дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэсэн 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.

Аймаг, нийслэлийн БТСГ:

Аймаг, нийслэлийн БТСГ-ын аудитаар шилэн дансанд байршуулах мэдээллээс нийт 47 мэдээлэл хугацаа хоцроож, 1,116.1 сая төгрөгийн 33 мэдээллийг байршуулаагүй зөрчилд 3 албан шаардлага 3 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Архангай аймгийн БТСГ нь 6 мэдээлэл, Өвөрхангай аймгийн БТСГ нь 12 мэдээлэл, Төв аймгийн БТСГ 22 мэдээлэл, Сүхбаатар дүүргийн БТСГ нь 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан; ;
- Дархан-Уул аймгийн БТСГ нь цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 26.6 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээг байршуулаагүй;

- Нийслэлийн БТСГ нь цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 292.8 сая төгрөгийн 13 мэдээлэл, орлогын 796.6 сая төгрөгийн 18 мэдээллийг байршуулаагүй.

4.4.2. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьяа байгууллагуудын аудитаар бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 155.8 сая төгрөгийн сая төгрөгийн 15 зөрчил илэрсэнд 88.8 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага, 67.0 сая төгрөгийн 9 зөвлөмж хүргүүлсэн байна.

Илрүүлэлт:

- Говьсүмбэр аймгийн БТСГ нь үндэсний тэмцээн, наадмын үйл ажиллагааны зардлаас 1.5 сая төгрөг, Дорноговь аймгийн БТСГ нь дэлхийн ноён оргил Эверестийн үндсэн отог Лобуче оргил, Кала паммер оргилуудад авирах замын зардлын дэмжлэг 1.0 сая төгрөгийг зардлын ангилал буруу олгосон.
- Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж Дорноговь аймгийн БТСГ нь бэлэг дурсгалд 1.0 сая төгрөг, цайны материалд 0.2 сая төгрөг, “албан хаагчдын нэгдсэн сургалт, спортын арга хэмжээ”-г зохион байгуулахад 1.1 сая төгрөг зарцуулсан.
- Дорнод аймгийн БТСГ нь үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагаанд 39.9 сая төгрөгийн төсөв баталсны 5.0 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэсэн байна. Энэ нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 34.4, 10.1.7-д заасантай нийцэхгүй.
- Дорнод аймгийн БТСГ нь орон тоог 9 хувиар цомхотгоогүй, 21 орон тоотой ажилласан.
- Сүхбаатар аймгийн БТСГ нь үр дүнгийн урамшуулал олгохдоо тогтоол журмын дагуу олгоогүй, Ховд аймгийн БТСГ нь албан хаагчдын үр дүнгийн урамшуулал олгохдоо ижил үнэлгээнд харилцан адилгүй хувиар урамшуулал олгосон.
- Баянхонгор аймгийн БТСГ нь ёс зүйн хорооны 5 гишүүдэд цалингийн 20 хувь болох 1,039.8 мянган төгрөг, Хэнтий аймгийн БТСГ нь ёс зүйн дэд хорооны 3 гишүүдэд 3,046.5 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон.
- Багахангай дүүргийн БТСХ нь 29.3 сая төгрөг, СХД БТСХ нь 66.6 сая төгрөгийн худалдан авалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд хүсэлт илгээж, худалдан авалт хийгээгүй.
- Багахангай дүүргийн БТСХ нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 3 нэр төрлийн 28.8 сая төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй цаашид ашиглах талаар шийдвэрлээгүй.
- СХД БТСХ нь 17.1 сая төгрөгийн бараа материалыг их хэмжээгээр нөөцөлсөн.
- Нийслэлийн БТСГ нь өмнөх аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлээгүй.
- БТСУХ нь албан хаагчдын албан хаагчдын ажилласан цагийг тооцохдоо цаг бүртгэлийн системд үндэслэн олгодоггүйгээс 11,12 дугаар сарын цагийн тооцоо 127 цагаар зөрүүтэй

4.4.3 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Биеийн тамир, спортын хорооны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар салбарын бодлого, хууль тогтоомжтой холбоотой 5 зөрчил илэрснээс 4 зөрчлийг дараагийн аудитаар анхаарах асуудалд оруулж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт:

Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь "Өсвөр үе, хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон тэмцээн уралдаан зохион байгуулах", "Спортын тэмцээн наадмын норматив, шаардлага, нээлт хаалтын дэг, соёл удирдлага, зохион байгуулах", "Орон тооны бус ёс зүйн зөвлөлийн ажиллах", "Улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах" зэрэг журмуудыг батлах хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс 15,732.0 сая төгрөгийг холбогдох журамгүй зарцуулсан байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т ""Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"", 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-д “өсвөр үе, хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт явуулах, тэмцээн уралдаан зохион байгуулах журам батлах”;10.1.3-д “биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүний дэргэдэх орон тооны бус Ёс зүйн зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, зөвлөлийн ажиллах журам батлах”; 10.1.8-д “спортын тэмцээн, наадмын норматив, шаардлага, нээлт, хаалтын дэг, соёл, удирдлага, зохион байгуулах журам батлах”; 10.1.9-д “улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах журам батлах. 34.1-д Энэ хуулийн 9.1.2, 9.1.4, 10.1.2, 23.4, 23.6, 28.1, 36.2-т заасан үйл ажиллагааг улсын төсвөөс”, 22.3-т заасныг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Спортыг дэмжих сангаас санхүүжүүлнэ” гэсэнтэй тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль дагасан журмуудыг боловсруулж, батлуулах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг нийцлийн асуудал нь Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1. Завсрын аудитын талаар

Биеийн тамир, спортын улсын хорооны завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 43,270.5 сая төгрөгийн 3 албан шаардлага өгсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 10. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	43,270,596.3	3	43,270,596.3	100
Нийт дүн	3	43,270,596.3	3	43,270,596.3	100

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж харьяа 10 байгууллага 422.9 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгсөн байна.
- Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас 2024 онд 27,438.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага өгсөн. Албан шаардлагыг хэрэгжүүлэхээр БТСУХ-оос дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр сургалт, зөвлөгөөг өгч ажилласан байна. Мөн тайлант онд нийт 12,581.2 сая төгрөгийн зөрчил илэрч өмнөх оноос 54.1 хувиар буурсан байна. Тиймээс хэрэгжилтийг 100 хувиар тооцов.
- Өмнөх онд 15,409.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг улсын төсвөөс олгосон боловч гэрээний биелэлтийг спортын холбоод бүрээр дүгнэж баталгаажуулаагүй байсан тул гэрээний биелэлтийг дүгнэх, хууль журмыг хэрэгжүүлэх талаар албан шаардлага өгсөн. Тайлант онд БТСУХ-оос санхүүжилт авсан 26 холбооны гэрээг дүгнэж ажилласан бөгөөд 7 үндэсний холбоо хангалтгүй, 11 холбоо олимпын эрх аваагүй, ДАШТ медаль аваагүй, 19 шигшээ баг хангалттай үнэлгээ авсан байна. Тиймээс хэрэгжилтийг 100 хувиар тооцов.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын спортын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтуудыг спортын салбарт хуваарилагдсан эсэх, шинээр

ашиглалтад орсон хөрөнгүүдийг бүртгэсэн эсэх, бүртгэлгүй хөрөнгө оруулалтууд байгаа эсэхэд горим сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- МУЗГ-ын 2024 оны 110 дугаар тогтоолоор Спортыг дэмжих санг хариуцахаар тогтоосон уг сангаас дэмжлэг үзүүлэх спортын төрөл, ангиллыг сонгох журам батлагдаагүй, санхүүгийн тайлан гаргаж байгаагүй, үйл ажиллагаа нь бүрэн зогссон, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хариуцан удирдах үүргээ хэрэгжүүлээгүй хэвээр байгаа асуудлуудыг дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Үндэсний шигшээ багуудыг бүрдүүлэх, хяналт тавих харилцааг зохицуулсан журам батлагдаагүй, өсвөр үе, залуучуудын шигшээ багийг дэмжих бодлого дутмаг, бүрэлдэхүүн аймаг, нийслэлд харилцан адилгүй, санхүүжилт тогтвортой бус байгаа нь Монгол улсын спортын амжилтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа тул дараагийн аудитаар ҮШБ-ийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, цаг ашиглалт, бүрдүүлэлт, орон нутгийн оролцоонд горим сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Алдар цолтой ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд нас барагчийн өв залгамжлагч нь тухайн иргэнийг нас барсан тухай төсвийн ерөнхийлөн захирагчид мэдэгдээгүй тохиолдолд төрд учирсан хохирлыг түүнээр нөхөн төлүүлэх тухай зохицуулалгүйн улмаас алдар цолтой ахмад настууд нас барсан хэдий ч уг нэмэгдэл олгогдсоор байх эрсдэлтэй байна. Улсын бүртгэлийн байгууллагаас нэмэгдэл, хөнгөлөлт олгогч байгууллагад тухайн ахмад настан нас барсан талаарх мэдээллийг ирүүлэх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна. Мөн БТСУХ нь дотоод хяналтыг сайжруулж ахмад насны мэдээллийн хөдөлгөөнд тогтмол хяналт хийх, төрийн байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах шаардлагатай байна.
- Өмнөх онд хууль бусаар ажлаасаа халагдсан 2 албан хаагчийн шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 32.1 сая төгрөгийг цалингийн зардлаас, 0.1 сая төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас олгосон ч буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаас төрд учруулсан хохирлыг төлүүлээгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 28,549.7 сая төгрөгийн 34 алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,396.4 сая төгрөгийн 77 зөрчил илэрснээс 174.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 20 төлбөрийн акт тогтоож, 3,149.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 22 албан шаардлага хүргүүлж, 5,040.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, санхүүгийн удирдлагыг сайжруулах 34 зөвлөмжийг хүргүүлж, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой 32.3 сая төгрөгийн 1 албан шаардлагыг дээд шатны дотоод аудитад өгсөн байна.

Залруулагдаагүй 8,396.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 33 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 12 байгууллага “Өөрчлөлтгүй”, 3 байгууллага “Хязгаарлалттай”, 1 байгууллага “сөрөг” дүгнэлт авч, 17 байгууллага түүвэрт хамрагдан 1 байгууллага дараах шалтгаанаар аудитад хамрагдаагүй байна.

Нийслэл, Дундговь, Өмнөговь аймгийн БТСГ -ууд нь “Хязгаарлалттай” дүгнэлт авсан бол Хөвсгөл аймгийн БТСГ нь “Сөрөг” дүгнэлт авсан байна.

5.1. Төлбөрийн акт

Харьяа байгууллага

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд нийт 36.3 сая төгрөгийн 14 төлбөрийн акт тогтоосон байна.

Түүврийн байгууллага

БТСУХ

1. Тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 1.4 сая төгрөгийн үрэлгэн зардал гаргаж төсвөөс төлсөн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" , 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Пара жудо бөхийн Үндэсний шигшээ багийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох багийн эмчийн зардалд илүү олгосон 3.2 сая төгрөгийг авлага дансанд бүртгээгүй, шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Албан хаагчдад 2.4 сая төгрөгийн албан томилолтын зардлыг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

4. Спортын холбоод нь Үндэсний шигшээ багт олгосон санхүүжилтийг зарцуулахдаа бүрэлдэхүүнд багтаагүй иргэдийн бэлтгэл сургуулилт, гадаад тэмцээн уралдаанд оролцох зардалд нийт 65.6 сая төгрөгийг тушаал, шийдвэрээс зөрүүтэй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д "улсын төсвөөс санхүүжүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5. Биатлоны Үндэсний шигшээ баг БТСУХ-ны даргын А/66 дугаар тушаалаар Дэлхийн цомын аварга шалгаруулах олимпын эрхийн оноо олгох Европын цуврал тэмцээн, бэлтгэлд хамрагдахдаа тушаалаас зөрүүтэй газарт тэмцээнд оролцож, мөн нэг тамирчин яваагүйгээс 49.1 сая төгрөгийн санхүүжилт хэмнэгдсэн байхад Биеийн тамир, спортын Улсын хороонд буцаан тушаагаагүй, тооцоо нийлж авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д "улсын төсвөөс санхүүжүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

6. Биеийн тамир, спортын улсын хороо нь өмнөх онуудад нас барсан 8 ахмадад нас барсан хугацаанаас хойш нэмэгдлийг тасралтгүй олгосоор ирсэн бөгөөд 2025 онд 16.1 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Ахмад настан нас барсан тохиолдолд нэмэгдлийг нас барсны дараачийн сар дуустал олгоно", 9.2-д "Хуурамч баримт бичиг бүрдүүлж нэмэгдэл, хөнгөлөлт авсан нь тогтоогдвол олголтыг зогсоож, олгогдсон нэмэгдэл, хөнгөлөлтийг нөхөн төлүүлнэ", 9.4-д "Энэ хуулийн 8.2-т заасан байгууллага болон холбогдох байгууллага, ажилтны буруугаас илүү олгосон нэмэгдэл, хөнгөлөлтийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн шийдвэрээр буруутай

албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.", Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-д "төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2. Албан шаардлага

Харьяа байгууллага

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд нийт 623.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 12 албан шаардлага өгсөн байна.

Түүврийн байгууллага

БТСУХ:

1. БТСУХ-ны даргын 2025 оны А/49, А/51, А/52, А/53, А/55, А/57, А/58, А/65, А/68, А/73, А/79, А/94 дугаартай "...үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүн батлах тухай" тушаалаар спортын холбоодод үндэсний шигшээ багийн тамирчин, эмч, дасгалжуулагч нарын 2025 оны 1-3 дугаар сарын цалин хөлс олгох санхүүжилтийг шилжүүлснээс тушаалын хавсралтад заасан багийн тамирчин, эмч, дасгалжуулагч нарын цалин хөлсийг 74.4 сая төгрөгөөр зөрүүтэй буюу бүрэлдэхүүнд багтаагүй тамирчид, дасгалжуулагч нарт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-т "улсын төсвөөс санхүүжүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах", 23 дугаар зүйлийн 23.2-т "Бие даасан бүтэцтэй байгуулах үндэсний шигшээ багийг тухайн спортын төрлийн холбооноос санал авсны үндсэн дээр бүрдүүлж, зохион байгуулна." 33 дугаар зүйлийн 33.1.2-т "үндэсний шигшээ багийн тамирчны цалингийн хэмжээ, урамшууллыг гаргасан амжилт, цол зэрэг, ур чадварыг харгалзан тусгайлан тогтоох" гэсэнтэй тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэрээс зөрүүтэй, шигшээ багийн бүрэлдэхүүнд байдаггүй тамирчид, дасгалжуулагч олгосон 74.4 сая төгрөгийг спортын холбоодтой тооцоо нийлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан нийт 986.4 сая төгрөг, оролцогчийг тэгш боломжоор хангаагүй 14.2 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан ажил үйлчилгээ болон худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.", 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 10 дугаар зүйлийн 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" 33 дугаар зүйлийн 33.1-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс

хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" гэсэнтэй нийцээгүй гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Албан хаагчдын албан тушаалын чиг үүрэгтэй давхардуулан хөлсөөр ажиллах гэрээ байгуулж нийт 40.9 сая төгрөгийн зардал гаргаж төсвийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4. Илүү цагаар ажилласан албан хаагчдад 6.0 сая төгрөгийн нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон Үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-д нийцүүлээгүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Төрийн захиргааны болон Үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 4 дүгээр зүйл "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно:", 5 дугаар зүйл "Дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачлагаар ажиллуулахыг хориглоно" 5.1-д "энэ журмын 4.1-4.4-т заасан тохиолдол" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, журамд нийцүүлээгүй илүү цагийн нэмэгдэл олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин Биеийн тамир, спортын улсын зөвлөлгөөн Дархан-Уул аймагт зохион байгуулж, тэмцээн уралдааны шагнал, урлагийн тоглолт, хоол унаа гэх мэт зардалд нийт 117.0 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: өрийн хэмнэлтийн тухай хуулийг холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилдаггүй, зориулалт бус зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

6. Орон нутаг, тив дэлхийн тэмцээн уралдаанд оролцсон тамирчид болон улсын хэмжээнд зохион байгуулсан тэмцээн уралдааны зардалд нийт 517.6 сая төгрөгийн 51 гүйлгээг холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарцуулалт, гүйцэтгэлийн тайлангүй байхад хэрэгжилтийг 100 хувиар тооцон гэрээ дүгнэсэн акт үйлдэж бүртгэлд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх

орлого" , 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэнтэй нийцээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого" , 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, бүртгэл тайланд тусгадаг зөрчлийг талсан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

7. Бараа материалын зарцуулалт, тайлагналтай холбоотой 323.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" , 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэнтэй нийцээгүй байна. █

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн хөтөлдөггүй, бөөн дүнгээр бүртгэж, зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

8. Биеийн Тамир, Спортын Улсын хороо нь олон жилийн турш өөрийн нэр дээр бүртгэлтэй байр, хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй ашиглуулсаар ирсэн байна.

Тайлант онд байрны ашигтай талбайн 71.7 хувь буюу 6238.36 м² талбайг ТӨБЗГ-ын зөшөөрөлгүй, сонгон шалгаруулалтгүй, үнэ төлбөргүй ашиглуулж, цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, халаалт, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалт, засвар үйлчилгээ гэх мэт байр ашиглалттай холбоотой бүхий л зардлыг Биеийн Тамир, Спортын Улсын хороо хариуцан 410.8 сая төгрөгийг төлсөн байна.

Гэтэл тус холбоод нь төрийн өмчийг дамжуулан түрээслэж, төлбөртэй сургалт, дугуйлангууд ажиллуулж, бусад клубуудад заал талбайг БТСУХ-оос зөвшөөрөл авалгүйгээр ашиглуулж, төрийн өмчийг хяналтгүй захиран зарцуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.", 27.2-д "Төрийн өмчийн газар, түүний хэвлий, төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эзэмшүүлэх, ашиглуулах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулахтай холбогдсон харилцааг Газрын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулна.", 28 дугаар зүйлийн 28.2-д "Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах

эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ", 28.5-д "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна." гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч хөрөнгийн ашигалалт хамгаалалтад хяналт хэрэгжүүлдэггүй, үнэ төлбөргүй түрээслэж, ашиглуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

9. Авлага дансанд 2 буюу түүнээс дээш жилийн насжилттай 33.4 сая төгрөгийн авлагыг багдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

САУЭШТ:

10. Түлш, шатах тослох материал данснаас 0.6 сая төгрөгийн шатахууныг жолоочийн тооцооны хуудасгүй, Эм боох материал данснаас 1,142.5 мянган төгрөгийн эм витаминыг Хандгайтын их тамирт сэргэлтийн бэлтгэлд гарсан тамирчдыг витаминжуулах зорилгоор авсан боловч эмчилгээний хуудасгүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

1. БТСУХ-ны дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 8,396.3 сая төгрөгийн 77 санхүүтэй холбоотой зөрчил илэрсэн нь өмнөх оноос 10,271.4 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитаар 20 зөрчилд 202.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 22 зөрчилд 3,149.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 34 зөрчилд 5,011.8 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж тус тус заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг 30.0 хувиас доошгүй бууруулах арга хэмжээг авч ажиллах, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

5.3. Зөвлөмж

Харьяа байгууллага

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 570.6 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 29 зөвлөмж өгсөн.

Түүврийн байгууллага

БТСУХ:

1. Тусгай олимпын Дэлхийн өвлийн наадамд оролцох 35 тамирчны хувцасны зардал гаргахаар шийдвэр гаргасан байхад 38 хувьцас авч, 1.2 сая төгрөгийн 3 хувцас илүү авсан, Олимпийн эрх олгох Европын цуврал тэмцээний зарцуулалтын 28.3 сая төгрөгийн баримт нөхөн бүрдүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог тушаал шийдвэрт нийцүүлэн үнэн зөв тайлагнаж зарцуулах зөвлөмж хүргүүлэх.

2. Монголын цанын холбоонд 10.3 сая төгрөг, Монголын биатлоны холбоонд 10.8 сая төгрөг, Парабайт харвааны холбоонд 4.9 сая төгрөгийн уураг, витаминжуулалтын зардлыг САУЭШТ-ийн чиг үүрэгтэй давхардуулан, хяналтгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, чиг үүргийн давхардал гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

3. БТСУХ нь 20 спортын холбоо (ТББ)-дод 872.9 сая төгрөгийн 958 ширхэг бараа материал, 1,672.3 сая төгрөгийн 698 ширхэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй өгч ашиглуулдаг, эдгээр холбоодтой Төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэхтэй холбоотой гэрээ байгуулаагүй байна. Аудитаар холбоодын ашиглаж байгаа хөрөнгөд түүвэрлэн тулгалт хийж үзэхэд БТСУХ-ноос өгсөн хөрөнгүүдийг коджуулаагүй байгаа нь хөрөнгөд тавих хяналт сул, хяналтгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.", 27.2-д "Төрийн өмчийн газар, түүний хэвлий, төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эзэмшүүлэх, ашиглуулах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулахтай холбогдсон харилцааг Газрын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулдаг, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч түрээсийн гэрээ байгуулдаггүй, хөрөнгийг зарцуулаагүй зөрчилүүдийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

4. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3,156 ширхэг 2,504.8 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3-ийн 1 "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн

үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгөд тавих хяналтыг сайжруулж, хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдэд стандартын дагуу бодит үнэ цэийг тогтоож, эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулж хөрөнгөд бүртгэх арга хэмжээ авч ажиллах.

5. Биеийн тамир, спортын цахим мэдээллийн сангийн программ хангамжийг хийж гүйцэтгэх 2020 оны БТСГ/202001007 дугаартай тендерээр гүйцэтгэсэн 236.7 сая төгрөгийн программ хангамжийг үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгөд тухайн үед бүртгээгүй, 2024 онд хийсэн хөгжүүлэлтийн 35.0 сая төгрөгөөр ТӨБЗГ-ийн шийдвэргүй үндсэн хөрөнгөд орлого авсан.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 4 дүгээр зүйлийн 4.1.2. "Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв бүртгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Дорнод аймгийн биеийн тамир, спортын газар	ДОА-2026/080/НА-СТА-ТШЗ	2	18,530,601.2	1	1,010,598.3	1	17,520,002.9	-	-	2	18,530,601.2		
15	Дундговь аймгийн биеийн тамир спортын газар	ДУА-2026/76/НА-СТА-ТШЗ	3	26,788.8	2	5,051.6		-	1	21,737.2	-	3	26,788.8	
16	Завхан аймгийн Биеийн тамир спортын газар	ЗАА-2026/148/НА-СТА-ТШЗ	2	11,676.8		-	2	11,676.8		-	-	2	11,676.8	
17	Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/503/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-	-	-	-	
18	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	НТАГ-2026/696/НА-СТА-ТШЗ	2	3,614.5		-		-	2	3,614.5	-	2	3,614.5	
19	Орхон аймгийн биеийн тамир спортын хороо	ОРА-2026/054/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-	-	-	-	
20	Өвөрхангай аймгийн биеийн тамир, спортын газар	ӨВА-2026/26/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-	-	-	-	
21	Өмнөговь аймгийн биеийн тамир, спортын газар	ӨМА-2026/138/НА-СТА-ТШЗ	4	612,599.5		-		-		-	4	612,599.5	4	612,599.5
22	Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/257/НА-СТА-ТШЗ	1	1,152.0		-		-		-	1	1,152.0	1	1,152.0
23	Сүхбаатар аймгийн биеийн тамир спортын газар	СБА-2026/135/НА-СТА-ТШЗ	1	124,046.0		-	1	124,046.0		-		1	124,046.0	
24	Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/258/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-	-	-	-	
25	Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газар	СЭА-2026/196/НА-СТА-ТШЗ	2	37,157.4		-	2	37,157.4		-		2	37,157.4	
26	Төв аймгийн Биеийн тамир, спортын газар	ТӨА-2026/143/НА-СТА-ТШЗ	1	1,468.1		-	1	1,468.1		-		1	1,468.1	
27	Увс аймгийн биеийн тамир спортын газар	УВА-2026/135/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-	-	-	-	
28	Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/259/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-	-	-	-	

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

29	Ховд аймгийн Биеийн тамир спортын газар	ХОА-2026/168/НА-СТА-ТШЗ	3	723,963.6	1	711,416.7		-		-	2	12,546.9	3	723,963.6		
30	Хөвсгөл аймгийн биеийн тамир, спортын газар	ХӨА-2026/143/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-		-	-	-		
31	Хэнтий аймгийн биеийн тамир спортын газар	ХЭА-2026/004/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-		-	-	-		
32	Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/260/НА-СТА-ТШЗ	-	-		-		-		-		-	-	-		
харьяа байгууллага			29	20,469,071.3	8	1,850,347.5	11	17,967,073.6	3	25,351.8	7	626,298.4	29	20,469,071.3		
1	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	САГ-2026/202/НА-СТА-ТШЗ	2	4,133.5		-	2	4,133.5		-		-	2	4,133.5		
2	Биеийн тамир спортын улсын хороо	САГ-2026/32/НА-СТА-ТШЗ	3	8,076,515.4	3	8,076,515.4		-		-		-	3	8,076,515.4		
түүвэр			5	8,080,648.9	3	8,076,515.4	2	4,133.5	-	-	-	-	5	8,080,648.9		
Нийт дүн			34	28,549,720.2	11	9,926,862.9	13	17,971,207.1	3	25,351.8	7	626,298.4	34	28,549,720.2		

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Аудитын код	Нийт зөрчил		Үүнээс											
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Дараагийн аудитаар шалгах асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Архангай аймгийн Биеийн тамир спортын газар	ДГА-2025/22/НА-СТА-ТШЗ	3	10,754.0	1	204.0	2	10,550.0	-	-	-	-	-	-	-	-
2	Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо	ЗАА-2025/068/НА-СТА-ТШЗ	-	23,495.0	-	-	-	-	1	23,495.0	-	-	-	-	-	-
3	Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороо	АРА-2025/12/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо	ХӨА-2025/185/НА-СТА-ТШЗ	2	74,831.2	-	-	-	-	2	74,831.2	-	-	-	-	-	-
5	Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар	БӨА-2025/031/НА-СТА-ТШЗ	6	124,440.7	2	19,385.3	2	85,174.3	2	19,881.0	-	-	-	-	-	-
6	Булган аймгийн Биеийн тамир, спортын газар	ХЭА-2025/007/НА-СТА-ТШЗ	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-	-	-
7	Говьсүмбэр аймгийн биеийн тамир, спортын газар	СБА-2025/004/НА-СТА-ТШЗ	1	2,170.0	-	-	-	-	1	2,170.0	-	-	-	-	-	-
8	Дархан-Уул аймгийн биеийн тамир, спортын газар	БУА-2025/066/НА-СТА-ТШЗ	1	471.3	1	471.3	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Дорноговь аймгийн биеийн тамир, спортын газар	ГАА-2025/056/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Дорнод аймгийн биеийн тамир, спортын газар	ГСА-2025/011/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Дундговь аймгийн биеийн тамир спортын газар	ДАА-2025/34/НА-СТА-ТШЗ	1	370,814.7	-	-	1	370,814.7	-	-	-	-	-	-	-	-
12	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	ДОА-2025/069/НА-СТА-ТШЗ	1	96,320.0	-	-	1	96,320.0	-	-	-	-	-	-	-	-
13	Орхон аймгийн биеийн тамир спортын хороо	ДУА-2025/76/НА-СТА-ТШЗ	2	9,345.0	-	-	1	9,345.0	1	-	-	-	-	-	-	-
14	Өвөрхангай аймгийн биеийн тамир спортын хороо	ОРА-2025/081/НА-СТА-ТШЗ	1	28,868.8	-	-	-	-	1	28,868.8	-	-	-	-	-	-
15	Өмнөговь аймгийн биеийн тамир, спортын газар	ӨМА-2025/019/НА-СТА-ТШЗ	6	91,198.6	-	-	-	-	6	91,198.6	-	-	-	-	-	-
16	Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо	УВА-2025/183/НА-СТА-ТШЗ	1	138,569.9	-	-	-	-	1	138,569.9	-	-	-	-	-	-
17	Сүхбаатар аймгийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2025/802/НА-СТА-ТШЗ	-	0.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
18	Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2025/803/НА-СТА-ТШЗ	1	2,994.7	-	-	-	-	1	2,994.7	-	-	-	-	-	-

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

19	Төв аймгийн Биеийн тамир, спортын газар	НТАГ-2025/453/НА-СТА-ТШЗ	6	7,775.3	3	1,032.2	2	3,052.6	1	3,690.5	-	-			
20	Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2025/806/НА-СТА-ТШЗ	1	94,513.4	-	-	-	-	1	94,513.4	-	-			
21	Ховд аймгийн Биеийн тамир спортын газар	НТАГ-2025/454/НА-СТА-ТШЗ	2	7,080.0	-	-	-	-	2	7,080.0	-	-			
22	Хөвсгөл аймгийн биеийн тамир, спортын газар	НТАГ-2025/807/НА-СТА-ТШЗ	15	135,502.4	6	7,230.3	2	44,934.2	7	83,338.0	-	-			
23	Хэнтий аймгийн биеийн тамир спортын газар	НТАГ-2025/808/НА-СТА-ТШЗ	2	10,875.1	1	7,943.7	1	2,931.4			-	-			
24	Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2025/452/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
25	Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газар	НТАГ-2025/804/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
26	Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/260/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
27	Баян-Өлгий аймгийн биеийн тамир спортын газар	БӨА-2026/045/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
28	Завхан аймгийн Биеийн тамир спортын газар	ЗАА-2026/148/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
29	Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/503/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
30	Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын хороо	СЭА-2026/196/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
31	Увс аймгийн Биеийн тамир, спортын хороо	УВА-2026/135/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
	Харьяа байгууллагын дүн			55	1,230,020.1	14	36,266.8	12	623,122.2	29	570,631.0	-	-	-	
32	Биеийн тамир спортын улсын хороо	СНАГ-2025/403/НА-СТА-ТШЗ	21	7,164,587.3	6	137,971.8	9	2,524,773.9	5	4,469,557.1	-	-	1	32,284.5	
33	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	СНАГ-2025/266/НА-СТА-ТШЗ	1	1,762.6			1	1,762.6			-	-			
	Түүврийн байгууллагын дүн			22	7,166,349.9	6	137,971.8	10	2,526,536.5	5	4,469,557.1	-	-	1	32,284.5
34	Биеийн тамир спортын улсын хорооны дарга	СНАГ-2025/018/НА-СТА-ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
	Төвлөрүүлэн захирагчийн дүн			-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
	Нийт дүн			77	8,396,370.0	20	174,238.7	22	3,149,658.7	34	5,040,188.1	-	-	1	32,284.5

Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

27	Баян-Өлгий аймгийн биеийн тамир спортын газар	БӨА-2026/045/НА-СТА-ТШЗ													
28	Завхан аймгийн Биеийн тамир спортын газар	ЗАА-2026/148/НА-СТА-ТШЗ													
29	Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хороо	НТАГ-2026/503/НА-СТА-ТШЗ													
30	Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын хороо	СЭА-2026/196/НА-СТА-ТШЗ													
31	Увс аймгийн Биеийн тамир, спортын хороо	УВА-2026/135/НА-СТА-ТШЗ													
Харьяа байгууллагын дүн			21	1,271,917,192	-	-	9	1,178,226,192	12	93,691,000	-	-	-	2	1,116,100.9
32	Биеийн тамир спортын улсын хороо	СНАГ-2025/403/НА-СТА-ТШЗ	7	2,853,618.8	-	-	1	2,853,618.8	5		-	-	1	1	2,853,618.8
33	Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	СНАГ-2025/266/НА-СТА-ТШЗ	1	59,336.9					1	59,336.9	-	-		1	59,336.9
Түүврийн байгууллагын дүн			8	2,912,955.7	-	-	1	2,853,618.8	6	59,336.9	-	-	1	2	2,912,955.7
34	Биеийн тамир спортын улсын хорооны дарга	СНАГ-2025/018/НА-СТА-ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-			
Төвлөрүүлэн захирагчийн дүн			-	-	-	-	-	-	-	-	-	-	-		-
Нийт дүн			29	4,184,872.9	-	-	10	4,031,845.0	18	153,027.9	-	-	1	4	4,029,056.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1225/А0171304

Улаанбаатар хот

САГ - 2026/1 | КА - СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа 34 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 103 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 8,396,370,140.00 (найман тэрбум гурван зуун ерэн зургаан сая гурван зуун далан мянга нэг зуун дөч) төгрөгийн 77 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 4,184,872,932.00 (дөрвөн тэрбум нэг зуун наян дөрвөн сая найман зуун далан хоёр мянга есөн зуун гучин хоёр) төгрөгийн 26 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх"; 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх"; 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг, алдаа зөрчлийг 30-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-564230



Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-35.Docx

1526181888



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 215/А0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн тамир, спортын улсын хороо нь өмнөх онуудад нас барсан 8 ахмад тухайн ахмадын нас барсан хугацаанаас хойш нэмэгдлийг тасралтгүй олгосоор ирсэн бөгөөд 2025 онд дээрх нас барсан 8 ахмадын нэр дээр нийт 16,125,000.00 (арван зургаан сая нэг зуун хорин таван мянган) төгрөгийн нэмэгдлийг зохих үндэслэлгүйгээр олгосон байна.

Энэ нь Ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Ахмад настан нас барсан тохиолдолд нэмэгдлийг нас барсны дараачийн сар дуустал олгоно", 9.2-д "Хуурамч баримт бичиг бүрдүүлж нэмэгдэл, хөнгөлөлт авсан нь тогтоогдвол олголтыг зогсоож, олгогдсон нэмэгдэл, хөнгөлөлтийг нөхөн төлүүлнэ", 9.4-д "Энэ хуулийн 8.2-т заасан байгууллага болон холбогдох байгууллага, ажилтны буруугаас илүү олгосон нэмэгдэл, хөнгөлөлтийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн шийдвэрээр буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.", Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-д "төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8. Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нас барсан ахмадуудад олгосон 16,125,000.00 (арван зургаан сая нэг зуун хорин таван мянган) төгрөгийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгт, ерөнхий нягтлан бодогч Б.Оюунцэцэг нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 216/A0171304

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА-СТА -ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн тамир, спортын улсын хорооноос тэмцээн, уралдааны санхүүжилтийг холбогдох спортын холбоодод олгон, уг санхүүжилтээр үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтсан тамирчдыг дотоодын болон олон улсын тэмцээн, уралдаанд оролцуулах ёстой байсан. Гэвч шалгалтаар үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаагүй 30 иргэнийг бэлтгэл сургуулилт болон гадаад тэмцээн, уралдаанд оролцуулахад нийт 65,608,100.00 (жаран таван сая зургаан зуун найман мянга нэг зуун) төгрөгийн санхүүжилтийг холбогдох тушаал, шийдвэрт зааснаас зөрүүтэйгээр зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д "улсын төсвөөс санхүүжүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтаагүй тамирчдад олгосон 65,608,100.00 (жаран таван сая зургаан зуун найман мянга нэг зуун) төгрөгийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгт, ерөнхий нягтлан бодогч Б.Оюунцэцэг, хавсралтад заасан спорт холбоодоор нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН.



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБЯАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 217/A0171304

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА -СТА -ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 2,400,000.00 (хоёр сая дөрвөн зуун мянган) төгрөгийн албан томилолтыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Илүү олгосон 2,400,000.00 (хоёр сая дөрвөн зуун мянган) төгрөгийн албан томилолтын гүйлгээг хянасан Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтээр нөхөн төлүүлж, ерөнхий нягтлан бодогч Б.Оюунцэцэг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 218/АД171304

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Пара жудо бөхийн Үндэсний шигшээ багийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох багийн эмчийн зардал 8,226,400.00 (найман сая хоёр зуун хорин зургаан мянга дөрвөн зуу) төгрөгийг эмчийн дансанд шилжүүлсэн боловч тус эмч нь яваагүй улмаас томилолтын зардал 5,501,700.00 (таван сая таван зуун нэг мянга долоон зуун) төгрөгийг Биеийн тамир, спортын улсын хорооны дансанд буцаан төлсөн, нислэгийн зардал болох 3,254,600.00 (гурван сая хоёр зуун тавин дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийг Пара жудо бөхийн холбооны санхүүжилтээс суутган тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Буцаан тушаагаагүй 3,254,600.00 (гурван сая хоёр зуун тавин дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийг Пара жудо бөхийн холбоогоор нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 219 /АД171304

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тушаал шийдвэр, анхан шатны баримтын бүрдэлгүй УБЗБ ХХК-д 1,477,900.00 (нэг сая дөрвөн зуун далан долоон мянга есөн зуун) төгрөгийн рестораны төлбөр төлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тушаал шийдвэр, анхан шатны баримтын бүрдэлгүй ашигласан 1,477,900.00 (нэг сая дөрвөн зуун далан долоон мянга есөн зуун) төгрөгийг гүйлгээг хянасан ерөнхий нягтлан бодогч Б.Оюунцэцэг, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБЯАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 220/A0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн тамир, спортын улсын хорооноос Үндэсний шигшээ багийн бэлтгэл, тэмцээнд оролцуулах зорилгоор Биеийн тамир, спортын улсын хорооны даргын А/66 дугаар тушаалаар Дэлхийн цомын аварга шалгаруулах, олимпын эрхийн оноо олгох Европын цуврал тэмцээн болон бэлтгэлд хамрагдахад Биатлоны холбоонд нийт 392,849,662.00 (гурван зуун ерэн хоёр сая найман зуун дөчин есөн мянга зургаан зуун жаран хоёр) төгрөгийн санхүүжилт олгосон. Тус санхүүжилтээс 343,743,455.00 (гурван зуун дөчин гурван сая долоон зуун дөчин гурван мянга дөрвөн зуун тавин тав) төгрөгийг зарцуулсан бөгөөд батлагдсан тушаалд зааснаас зөрүүтэй байршил газарт, тэмцээнд оролцсон зөрчил илэрсэн. Мөн нэг тамирчин тэмцээн, бэлтгэлд яваагүйтэй холбоотойгоор 49,106,207.00 (дөчин есөн сая нэг зуун зургаан мянга хоёр зуун долоо) төгрөгийн санхүүжилт хэмнэгдсэн боловч уг мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д "улсын төсвөөс санхүүжүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8.Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Буцаан тушаагаагүй санхүүжилт 49,106,207.00 (дөчин есөн сая нэг зуун зургаан мянга хоёр зуун долоо) төгрөгийг Биатлоны холбооны өмнөх Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Мөнх-Адьяа, нягтлан бодогч Э.Мөнхболд, одоогийн Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Ганзориг, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Э.Билэгт, өмнөх ерөнхий нягтлан бодогч А.Өнөрцэцэг нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1154/А0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан нийт 986,453,600.00 (есөн зуун наян зургаан сая дөрвөн зуун тавин гурван мянга зургаан зуун) төгрөг, тендер зарлаагүй 234,175,000.00 (хоёр зуун гучин дөрвөн сая нэг зуун далан таван мянган) төгрөгийн шууд гэрээ байгуулан ажил үйлчилгээ болон худалдан авалт хийсэн байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.", 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 10 дугаар зүйлийн 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" 33 дугаар зүйлийн 33.1-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" гэсэнтэй нийцээгүй гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1155/А0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэлдэхүүн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/49, А/51, А/52, А/53, А/55, А/57, А/58, А/65, А/68, А/73, А/79, А/94 дугаартай "...үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүн батлах тухай" тушаалаар спортын холбоодод үндэсний шигшээ багийн тамирчин, эмч, дасгалжуулагч нарын 2025 оны 1-3 дугаар сарын цалин хөлс олгох санхүүжилтийг шилжүүлснээс тушаалын хавсралтад заасан багийн тамирчин, эмч, дасгалжуулагч нарын цалин хөлсийг 74,366,400.00 (далан дөрвөн сая гурван зуун жаран зургаан мянга дөрвөн зуун) төгрөгөөр зөрүүтэй буюу бүрэлдэхүүнд багтаагүй тамирчид, дасгалжуулагч нарт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-т "улсын төсвөөс санхүүжүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах", 23 дугаар зүйлийн 23.2-т "Бие даасан бүтэцтэй байгуулах үндэсний шигшээ багийг тухайн спортын төрлийн холбооноос санал авсны үндсэн дээр бүрдүүлж, зохион байгуулна." 33 дугаар зүйлийн 33.1.2-т "үндэсний шигшээ багийн тамирчны цалингийн хэмжээ, урамшууллыг гаргасан амжилт, цол зэрэг, ур чадварыг харгалзан тусгайлан тогтоох" гэсэнтэй тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тушаал шийдвэрээс зөрүүтэй, шигшээ багийн бүрэлдэхүүнд байдаггүй тамирчид, дасгалжуулагч нарт олгосон 74,366,400.00 (далан дөрвөн сая гурван зуун жаран зургаан мянга дөрвөн зуун) төгрөгийг спортын холбоодтой тооцоо нийж, зөрчлийг арилгаж 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1156/АД171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутаг, тив дэлхийн тэмцээн уралдаанд оролцсон тамирчид болон улсын хэмжээнд зохион байгуулсан тэмцээн уралдааны зардалд нийт 517,661,700.00 (таван зуун арван долоон сая зургаан зуун жаран нэг мянга долоон зуу) төгрөгийн 51 гүйлгээг холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарцуулалт, гүйцэтгэлийн тайлангүй байхад хэрэгжилтийг 100 хувиар тооцон гэрээ дүгнэсэн акт үйлдэж бүртгэлд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, бүртгэл тайланд тусгадаг зөрчлийг талсан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1157/А0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА -СТА -ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын зарцуулалт, тайлагналтай холбоотой 323,768,738.00 (гурван зуун хорин гурван сая долоон зуун жаран найман мянга долоон зуун гучин найман/ төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Нэг бүрийн үнэ, тоо ширхэг, нэр төрлийг нэг бүрчлэн тусгаагүй, бөөн дүнтэй хэдэн ширхэг, ямар төрлийн бараа худалдан авсан нь тодорхойгүй анхан шатны баримтаар нийт 161,156,200.00 (нэг зуун жаран нэгэн сая нэг зуун тавин зургаан мянга хоёр зуун) төгрөгийн материал худалдан авч орлого авч зардал гаргасан;
- Тооцооны дансаар дамжуулалгүй 9,736,000.00 (есөн сая долоон зуун гучин зургаан мянган) төгрөгийн бараа материалыг шууд зардалд бичсэн байна.
- Жолоочийн тооцооны хуудасгүй 7,563,000.00 (долоон сая таван зуун жаран гурван мянган) төгрөгийн шатахууныг зарцуулсан;
- Тайлант хугацаанд 17,500,000.00 (арван долоон сая таван зуун мянга) төгрөгийн 500 ширхэг чихмэл тоглоом, 14,175,000.00 (арван дөрвөн сая нэг зуун далан таван мянган) төгрөгийн 450 ширхэг ном, 36,120,000.00 (гучин зургаан сая нэг зуун хорин мянган) төгрөгийн 6324 ширхэг мандат, гэр, оосор, 5,448,000.00 (таван сая дөрвөн зуун дөчин найман мянган) төгрөгийн 100 ширхэг туг, 48,622,100.00 (дөчин найман сая зургаан зуун хорин хоёр мянга нэг зуун) төгрөгийн 2178 ширхэг медаль, 3,875,000.00 (гурван сая найман зуун далан таван мянган) төгрөгийн 25 ширхэг тамирчдын хувцас, 8,525,000.00 (найман сая таван зуун хорин таван мянган) төгрөгийн 550 ширхэг тэмдэглэлийн дэвтэр, 11,048,400.00 (Арван нэгэн сая дөчин найман мянга дөрвөн зуун) төгрөгийн 1674 ширхэг мастер спортын цолны тэмдэг, үнэмлэх, нийт 145,313,500.00 (нэг зуун дөчин таван сая гурван зуун арван гурван мянга таван зуун) төгрөгийн бараа материалыг тараалтын хуудасгүй, зарцуулалтыг нотлох баримтгүй, хэнд өгсөн нь тодорхойгүй бөөн дүнгээр зарлагдсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "бүх орлого", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Анхан шатны баримтыг бүрэн хөтөлдөггүй, бөөн дүнгээр бүртгэж, зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1158/АДИТ 1304

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн Тамир, Спортын Улсын хороо нь олон жилийн турш өөрийн нэр дээр бүртгэлтэй байр, хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй ашиглуулсаар ирсэн байна.

Тайлант онд байрны ашигтай талбайн 71.7 хувь буюу 6238.36 м2 талбайг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй, сонгон шалгаруулалтгүй, үнэ төлбөргүй ашиглуулж, цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, халаалт, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалт, засвар үйлчилгээ гэх мэт байр ашиглалттай холбоотой бүхий л зардлыг Биеийн Тамир, Спортын Улсын хороо хариуцан 410,829,810.00 (дөрвөн зуун арван сая найман зуун хорин есөн мянга найман зуун арван) төгрөгийг төлсөн байна.

Гэтэл тус холбоод нь төрийн өмчийг дамжуулан түрээсэлж, төлбөртэй сургалт, дугуйлангууд ажиллуулж, бусад клубүүдэд заал талбайг Биеийн тамир, спортын улсын хорооноос зөвшөөрөл авалгүйгээр ашиглуулж, төрийн өмчийг хяналтгүй захиран зарцуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.", 27.2-д "Төрийн өмчийн газар, түүний хэвлий, төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эзэмшүүлэх, ашиглуулах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулахтай холбогдсон харилцааг Газрын тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулна.", 28 дугаар зүйлийн 28.2-д "Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ", 28.5-д "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна." гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-д "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт хэрэгжүүлдэггүй, үнэ төлбөргүй түрээслэж, ашиглуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1159/А0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА -СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлага дансанд 2 буюу түүнээс дээш жилийн насжилттай 33,447,100.00 (гучин гурван сая дөрвөн зуун дөчин долоон мянга нэг зуун) төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-г "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Олон жилийн насжилттай 33,447,100.00 (гучин гурван сая дөрвөн зуун дөчин долоон мянга нэг зуун) төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

САХХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1160/А0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 660,482,700.00 (зургаан зуун жаран сая дөрвөн зуун наян хоёр мянга долоон зуу) төгрөгийн зарлагын гүйлгээ, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 2,253,136,100.00 (хоёр тэрбум хоёр зуун тавин гурван сая нэг зуун гучин зургаан мянга нэг зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр нийт 2,853,618,800.00 (хоёр тэрбум найман зуун тавин гурван сая зургаан зуун арван найман мянга найман зуун) төгрөгийн мэдээллийг мэдээллээгүй, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1161/АД171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдын албан тушаалын чиг үүрэгтэй давхардуулан хөлсөөр ажиллах гэрээ байгуулж нийт 40,980,000.00 (дөчин сая есөн зуун наян мянган) төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Албан тушаалын чиг үүрэгтэй давхардуулан, төсөвт тусгагдаагүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1162/A0171304

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Илүү цагаар ажилласан албан хаагчдад нэмэгдэл олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон Үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-д нийцүүлээгүй 6,003,400.00 (зургаан сая гурван мянга дөрвөн зуун) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Төрийн захиргааны болон Үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 4 дүгээр зүйл "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно." 5 дугаар зүйл "Дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахыг хориглоно" 5.1-д "энэ журмын 4.1-4.4-т заасан тохиолдол" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Хууль, журамд нийцүүлээгүй илүү цагийн нэмэгдэл олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР

9006109

ATA 16037

392558741



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1163/А0171304

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин Биеийн тамир, спортын улсын зөвлөгөөн Дархан-Уул аймагт зохион байгуулж, тэмцээн уралдааны шагнал, урлагийн тоглолт, хоол унаа гэх мэт зардалд нийт 117,088,000.00 (зуун арван долоо сая наян найман мянган) төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилладаггүй, зориулалт бус зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Билэгт), ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунцэцэг) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ЭГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Э.ЦЭЛМЭГБАЯР